



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2022.02.14 № 1-6/43

танай _____-ны № _____-т

**ХАТАНБУЛАГ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Б.НАВЧАА ТАНАА**

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хатанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Хатанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тус байгууллага нь тайлант онд сумын Залуучуудын чуулга уулзалтыг зохион байгуулж, нийт оролцсон залууст саравчтай малгай, цамцыг төсвийн хөрөнгөөр худалдан авахад 2.2 сая төгрөг, байгууллагын түүхт 30 жилийн ойн хүрээнд сургалт, зөвлөгөөн, уулзалтыг танхимаар зохион байгуулж, хоол хүнсний зардалд 2.0 сая төгрөг, Дэлхий аавуудын баярын арга хэмжээний хүрээнд суманд дүрс бичлэгийг хийлгэхэд 0.8 сая төгрөгийн зарцуулсан, мөн өмнөх оноос бичиг хэргийн бодит зардал 0.1 сая төгрөгөөр өссөн. Тайлант онд нийт 5.1 сая төгрөгийн төсвийг үр ашиггүй зарцуулж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-д "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад

0100003-9

зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх", 15.2.3-т "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх", 15.2.4-д "бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэх", Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1-д "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчих..." гэж заасныг тус тус зөрчиж, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Төсвийн санхүүжилтийг тайлант онд 5.3 сая төгрөгөөр хэмнэж, төсөв 94.7 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь албан хаагчдын цалингийн хөлс, урамшууллын зардал болон нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 5.0 сая төгрөгөөр хэмнэлт үүссэнтэй холбоотой байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг чанаргүй гүйцэтгэж, тус байгууллагад бодитоор оршин байгаагүй 2.2 сая төгрөгийн бараа материал, 1.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг тоолсон мэтээр тооллогын бүртгэлд тусгасан.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд бусад асуудлын хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.ГАН-ӨЛЗИЙ





САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хатанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2023/30/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Сайншанд сум 2023 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 7052-2734 Цахим хаяг: Gan-Ulziit@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 7052-3020 Цахим хаяг: Oyuntulkhuur.u@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ч.Хэрлэнчимэг Утас: 7052-3020 Цахим хаяг: Kherlenchimegch@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	төгрөгөөр	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	11,222,965.00	8,439,020.00
33	АВЛАГА	2,068,570.00	912,270.00
335	Бусад авлага	2,068,570.00	912,270.00
3351	Байгууллагаас авах авлага	2,068,570.00	912,270.00
35	БАРАА МАТЕРИАЛ	9,154,395.00	7,526,750.00
354	Хангамжийн материал	9,154,395.00	7,526,750.00
35410	Бичиг хэргийн материал	3,924,513.00	3,658,868.00
35420	Аж ахуйн материал	3,131,882.00	3,612,882.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,130,000.00	255,000.00
35440	Түлш, шатах тослох материал	968,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	14,150,573.87	13,285,351.42
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	14,150,573.87	13,285,351.42
392	Биет хөрөнгө	13,950,573.87	13,152,018.14
39203	Авто-тээврийн хэрэгсэл	16,000,000.00	16,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(16,000,000.00)	(16,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	17,809,270.00	18,118,370.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(6,154,139.34)	(8,223,092.42)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,227,890.00	6,445,200.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(4,978,346.79)	(5,068,866.11)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	1,865,600.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(31,093.33)
39217	Ном	45,900.00	45,900.00
393	Биет бус хөрөнгө	200,000.00	133,333.28
39301	Програм хангамж	1,630,000.00	200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,430,000.00)	(66,666.72)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	25,373,538.87	21,724,371.42
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	230,401.00	2,830.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	230,401.00	2,830.00
413	Өглөг	230,401.00	2,830.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	228,001.00	-
4136	Бусад өглөг	2,400.00	2,830.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	2,400.00	2,830.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	25,143,137.87	21,721,541.42
51	Засгийн газрын хувь оролцоо	25,143,137.87	21,721,541.42
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,284,200.00	3,284,200.00
512	Хуримтлагдсан үр дүн	21,794,878.37	18,409,801.42
51210	Өмнөх үеийн үр дүн	21,794,878.37	21,597,855.03
51220	Тайлант үеийн үр дүн	-	(3,188,053.61)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	64,059.50	27,540.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	25,373,538.87	21,724,371.42

4417144353
EHOA0056 9025707

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	төгрөгөөр	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	103,782,288.00	101,891,571.77
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	103,782,288.00	101,891,571.77
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,858,700.00	6,080,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,858,700.00	6,080,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	93,923,588.00	95,811,571.77
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	93,923,588.00	95,811,571.77
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	103,155,527.72	105,079,625.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	103,155,527.72	105,079,625.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	100,705,527.72	102,754,625.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	61,455,791.00	55,424,279.00
210101	Үндсэн цалин	47,384,905.24	34,875,616.00
210102	Нэмэгдэл	-	9,677,887.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,055,975.76	212,000.00
210104	Урамшуулал	13,014,910.00	10,658,776.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,958,362.00	6,863,151.77
210201	Тэтгэврийн даатгал	6,514,129.00	5,156,959.52
210202	Тэтгэмжийн даатгал	374,597.00	373,162.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	295,392.00	299,009.94
210204	Ажилгүйдлийн даатгал	81,794.00	106,752.50
210205	Эрүүл мэндийн даатгал	692,450.00	927,267.37
2104	Хангамж, бараа материалын зардал	10,920,310.00	20,850,555.00
210401	Бичиг хэрэг	2,410,150.00	4,664,145.00
210402	Тээвэр, шатахуун	5,532,000.00	10,415,060.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,340,000.00	585,100.00
210404	Ном, хэвлэл	381,160.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,138,000.00	5,186,250.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	119,000.00	-
2105	Нормативт зардал	3,452,470.00	6,451,650.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	316,000.00	-
210502	Хоол, хүнс	3,136,470.00	6,451,650.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,175,800.00	2,286,400.00
210604	Урсгал засвар	4,175,800.00	2,286,400.00
2107	Томилолт, зочны зардал	326,000.00	688,800.00
210702	Дотоод албан томилолт	326,000.00	688,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,739,688.57	4,613,610.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,631,013.57	4,528,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	81,675.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	5,000.00	63,610.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00

4417144353
EHOA0056 9025707


2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,677,106.15	5,576,179.61
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	360,600.00	500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,980,050.00	1,050,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	4,336,456.15	4,026,179.61
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,450,000.00	2,325,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,450,000.00	2,325,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,450,000.00	2,325,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	626,760.28	(3,188,053.61)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	48,333.27	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	48,333.27	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(48,333.27)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	578,427.01	(3,188,053.61)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	төгрөгөөр	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	103,782,288.00	103,942,971.77
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	103,782,288.00	103,942,971.77
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,858,700.00	8,131,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,858,700.00	6,080,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	2,051,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	93,923,588.00	95,811,571.77
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	93,923,588.00	95,811,571.77
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	100,692,288.00	100,548,471.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	100,692,288.00	100,548,471.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	98,092,288.00	99,150,871.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	62,698,920.00	55,652,280.00
210101	Үндсэн цалин	48,628,034.24	36,206,152.00
210102	Нэмэгдэл	-	8,575,352.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,055,975.76	212,000.00
210104	Урамшуулал	13,014,910.00	10,658,776.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,715,233.00	6,863,151.77
210201	Тэтгэврийн даатгал	5,271,000.00	5,044,969.36
210202	Тэтгэмжийн даатгал	374,597.00	451,411.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	295,392.00	369,988.98
210204	Ажилгүйдлийн даатгал	81,794.00	81,922.25
210205	Эрүүл мэндийн даатгал	692,450.00	914,859.95
2104	Хангамж, бараа материалын зардал	9,399,760.00	10,242,460.00
210401	Бичиг хэрэг	1,000,000.00	1,081,400.00
210402	Тээвэр, шатахуун	6,500,000.00	8,128,560.00

4417144353
ЕНОА0056 9025707

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,100,000.00	799,500.00
210404	Ном, хэвлэл	799,760.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	233,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,220,000.00	1,496,400.00
210604	Урсгал засвар	2,220,000.00	1,496,400.00
2107	Томилолт, зочны зардал	326,000.00	688,800.00
210702	Дотоод албан томиллолт	326,000.00	688,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,307,375.00	7,319,110.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,198,700.00	7,233,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	81,675.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	5,000.00	63,610.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,425,000.00	16,888,670.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	11,910,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,425,000.00	4,978,270.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,600,000.00	1,397,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	600,000.00	600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	600,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,000,000.00	797,600.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,000,000.00	797,600.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	3,090,000.00	3,394,500.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,090,000.00	3,394,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,090,000.00	3,394,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,090,000.00	3,394,500.00
222001	Тоног төхөөрөмж	3,090,000.00	1,528,900.00
223001	Бусад хөрөнгө	-	1,865,600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(3,090,000.00)	(3,394,500.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-




 4417144353
 EIC0A0056 9025707

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,284,200.00	64,059.50	21,794,878.37		25,143,137.87
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	(197,023.34)		(197,023.34)
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	(36,519.50)	00.00		(36,519.50)
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00		00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00		00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	(705,053.61)		(705,053.61)
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,284,200.00	64,059.50	21,794,878.37	00.00	25,143,137.87
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(197,023.34)		(197,023.34)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				-	-
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(36,519.50)	-		(36,519.50)
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-		-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-		-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(3,188,053.61)		(3,188,053.61)
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,284,200.00	27,540.00	18,409,801.42	-	21,721,541.42



 4417144353
 ЕҮОА0056 9025707



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	101,103,700.00	95,811,571.77	5,292,128.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	101,103,700.00	95,811,571.77	5,292,128.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	100,503,700.00	95,211,571.77	5,292,128.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	59,951,100.00	55,652,280.00	4,298,820.00
210101	Үндсэн цалин	34,000,000.00	36,206,152.00	(2,206,152.00)
210102	Нэмэгдэл	13,809,100.00	8,575,352.00	5,233,748.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	738,000.00	212,000.00	526,000.00
210104	Урамшуулал	11,404,000.00	10,658,776.00	745,224.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,542,600.00	6,863,151.77	679,448.23
210201	Тэтгэврийн даатгал	5,476,800.00	5,044,969.36	431,830.64
210202	Тэтгэмжийн даатгал	871,700.00	451,411.23	420,288.77
210203	ҮОМШӨ-ний даатгал	361,900.00	369,988.98	(8,088.98)
210204	Ажилгүйдлийн даатгал	175,900.00	81,922.25	93,977.75
210205	Эрүүл мэндийн даатгал	656,300.00	914,859.95	(258,559.95)
2104	Хангамж, бараа материалын зардал	9,800,000.00	9,797,960.00	2,040.00
210401	Бичиг хэрэг	1,000,000.00	999,400.00	600.00
210402	Тээвэр, шатахуун	8,000,000.00	7,999,060.00	940.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	800,000.00	799,500.00	500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	1,496,400.00	3,600.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,496,400.00	3,600.00
2107	Томилолт, зочны зардал	700,000.00	688,800.00	11,200.00
210702	Дотоод албан томилолт	700,000.00	688,800.00	11,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,010,000.00	5,734,710.00	275,290.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,650,000.00	5,649,100.00	900.00
210803	Даатгалын үйлчилгээ	150,000.00	-	150,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	63,610.00	86,390.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000.00	22,000.00	38,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,000,000.00	14,978,270.00	21,730.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,000,000.00	10,000,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,000,000.00	4,978,270.00	21,730.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	600,000.00	600,000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	600,000.00	600,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	600,000.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	101,103,700.00	95,811,571.77	5,292,128.23
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	101,103,700.00	95,811,571.77	5,292,128.23
132001	Орон нутгийн төсвөөс	101,103,700.00	95,811,571.77	5,292,128.23
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			

4417144353
ЕНОА0056 9025707

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		8,131,400.00	(8,131,400.00)
21	УРСГАЛ ЗАРДАЛ		8,131,400.00	(8,131,400.00)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		7,333,800.00	(7,333,800.00)
2104	Хангамж, бараа материалын зардал	-	444,500.00	(444,500.00)
210401	Бичиг хэрэг	-	82,000.00	(82,000.00)
210402	Тээвэр, шатахуун	-	129,500.00	(129,500.00)
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	233,000.00	(233,000.00)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	3,780,000.00	(3,780,000.00)
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	3,780,000.00	(3,780,000.00)
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	3,109,300.00	(3,109,300.00)
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	3,109,300.00	(3,109,300.00)
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	797,600.00	(797,600.00)
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	797,600.00	(797,600.00)
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		797,600.00	(797,600.00)
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	8,131,400.00	(8,131,400.00)
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	8,131,400.00	(8,131,400.00)
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	6,080,000.00	(6,080,000.00)
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	2,051,400.00	(2,051,400.00)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-

4417144353
EHOA0056 9025707

Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 77.8 сая төгрөгийн дараах 5 алдаа¹ илэрч, аудитын явцад 75.7 сая төгрөгийн 4 алдааг залруулсан. Үүнд, зардлын ангилал зөрүүлэн 3.2 сая төгрөгийн 13 гүйлгээг бүртгэсэн, харилцах данснаас шилжүүлсэн 8.6 сая төгрөгийн зардлыг тооцооны дансанд тусгахгүйгээр шууд зардлын дансанд бүртгэсэн, тайлант оны 9-10 дугаар сард зарцуулсан 2.3 сая төгрөгийн бараа материалын зарлагын гүйлгээг бүртгээгүй, цалингийн зардал дансанд гүйлгээг давхардуулсан, эсхүл дутуу бүртгэснээс зардлыг 61.6 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн.

Аудитын явцад залруулах боломжгүй 2.1 сая төгрөгийн 1 алдааг дахин үнэн зөв тооцоолж, холбогдох өр төлбөрийг тооцоо бодсон баримтаар баталгаажуулж, залруулах зөвлөмжийг хүргүүлэв.

Аудитаар нийт 9.1 сая төгрөгийн 6 зөрчил² илэрч, 5.1 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 4.0 сая төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж хүргүүлэв.

3.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

3.2 Албан шаардлага

1. Бичиг хэргийн зардал өмнөх оноос 2.2 сая төгрөгөөр буюу 93 хувиар өссөн байна. Үүнд, 1.7 сая төгрөг тайлант онд хийлгэсэн CD, хулдаасан хэвлэл зарэг бараа материал, хуулийн гарын авлагыг зарцуулснаас үүссэн. Бичгийн цаасны зардал 0.2 сая төгрөгөөр өссөн байгаа боловч үүнд үнийн дүнгээс шалтгаалсан өсөлтийг харгалзан тооцоход 0.1 сая төгрөгөөр бичгийн цаасны бодит хэрэглээ өссөн байна.

Байгууллагын түүхт 30 жилийн ойн хүрээнд сургалт, зөвлөгөөн, уулзалтыг танхимаар зохион байгуулж, бичиг хэрэг, хоол хүнс болон бусад зардлыг зарцуулсан. Үүнээс, сургалтын зохион байгуулалтын зардлыг хасахад 2.0 сая төгрөгийн хоол хүнсний зардлыг үр ашиггүй зарцуулж, төрийн хэмнэлтийг горимыг мөрдөөгүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т “сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх”, 15.2.4-д “бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

2. Тус байгууллага нь тайлант онд сумын Залуучуудын чуулга уулзалтыг зохион байгуулж, нийт оролцсон залууст 2.2 сая төгрөгийн 130 ширхэг саравчтай малгай, цамцыг төсвийн хөрөнгөөр авч өгсөн, мөн Дэлхий аавуудын баярын арга хэмжээний дүрс бичлэгийг 0.8 сая төгрөгөөр хийлгэж, төсвийг үр ашиггүй зарцуулжээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-д “Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх”, Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1-д “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчих...” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд,

1. Эд хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Тайлант оны 9 дүгээр сард зохион байгуулсан сумын залуучуудын чуулга уулзалтаар 2.2 сая төгрөгийн 130 ширхэг малгай, захтай цамцыг худалдан авч, уулзалтад оролцсон иргэдэд тарааж өгч, ижилссэн байна. Эдгээр хувцсыг оролцогчдоос буцааж аваагүй байтал жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын бүртгэлд тус хөрөнгийг байгаа мэтээр тусгаж, тооллогын чанаргүй гүйцэтгэсэн байна. Бодитоор оршин байхгүй хөрөнгийг санхүүгийн тайланд үлдэгдэлтэй мэтээр тусгах нь байгууллагын хөрөнгийг хийсвэрээр нэмэгдүүлэх, санхүүгийн тайлан дахь бараа материалын үлдэгдэл буруу илэрхийлэгдэх үр дагавартай.

Дээрх зөрчил нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 4.1-д “тооллогын комисс дараах үүрэгтэй ... хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах” гэж заасантай нийцэхгүй байна.

- 1.2. Өгсөн зөвлөмж: Эд хөрөнгийн тооллогын чанартай, үнэн зөв гүйцэтгэж, тооллогын бүртгэлд бодитоор оршин байгаа хөрөнгийг тусгаж, баталгаажуулах.

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

- 2.1. Илрүүлэлт: Тайлант онд 1.9 сая төгрөгийн 1 төрлийн 8.48 м.кв цонхны хамгаалалтыг тус сумын сургуульд тайлант оны 12 дугаар сард шилжүүлсэн боловч зарлагын баримтыг үйлдээгүйн улмаас ИТХ-ын санхүүгийн тайланд бүртгэлтэй байна. Энэ нь байгууллагын хөрөнгийн үлдэгдлийг хийсвэрээр нэмэгдүүлэх, санхүүгийн тайлан дахь үндсэн хөрөнгийн үлдэгдэл буруу илэрхийлэгдэх үр дагавартай.

Уг зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.1-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ... аж ахуйн бүх ажил, гүйлгээ” гэж заасантай нийцэхгүй байна.

- 2.2. Өгсөн зөвлөмж: Сумын ИТХ-ын санхүүгийн тайланд бүртгэлтэй байгаа боловч сургуулийн эзэмшилд шилжүүлсэн 1.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг холбогдох тушаал шийдвэрт үндэслэн ашиглагч байгууллагад шилжүүлэх.

3. Цалингийн зардал, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт: Тайлант оны цалингийн зардлыг 0.6 сая төгрөгөөр дутуу, нийгмийн даатгалын тайланд албан хаагчдаас суутгасан шимтгэлийг 0.1 сая төгрөгөөр дутуу тусгасан. Нягтлан бодох бүртгэлд татвар болон шимтгэлийн суутгалыг зөрүүтэй бүртгэсэн, ажил олгогчоос олгох нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 0.4 сая төгрөгөөр дутуу тусгасан, мөн цалингийн зардал болон суутгалын бичилтийг бүртгэлд буруу тусгасан байна. Албан хаагчдаас суутгасан татварын тайланг бэлтгээгүй, татварын байгууллагатай тооцоо нийлээгүй учир аудитын явцад зардал, суутгалыг залруулах боломжгүй байв.

Энэ алдаа нь тайлант оны зардал, өр төлбөрийг буруу илэрхийлэх үр дагаврыг бий болгож байна.

Дээрх алдаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ...нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар-ын 3.6 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

3.2. Өгсөн зөвлөмж: Тайлант 2022 оны цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, албан хаагчдаас суутгасан татвар, шимтгэлийн зардлын тооцооллыг давтан үнэн зөв гүйцэтгэж, зардал, өр төлбөрийг 2023 оны тайланд залруулан бүртгэх.

Дөрөв. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн	Тоо	Дүн
Зардлын зүйл ангиллыг зөрүүтэй бүртгэсэн	1	3,181.6			1	3,181.6	1	3,181.6				
Шууд зардалд тусгасан	1	8,620.6			1	8,620.6	1	8,620.6				
Зарцуулсан бараа материалыг зарлагдаагүй	1	2,280.0			1	2,280.0	1	2,280.0				
Цалингийн зардлыг зөрүүтэй тайлагнасан	1	61,634.4			1	61,634.4	1	61,634.4				
Цалингийн бүртгэлийг зөрүүтэй бичсэн	1	2,131.3			1	2,131.3			1	2,131.3	1	2,131.3
Дүн	5	77,847.9	-	-	5	77,847.9	4	75,716.6	1	2,131.3	1	2,131.3

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төсвийг үр ашиггүй зарцуулсан	1	3,088.0			1	3,088.0	-	-	-	-	-	-
Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлээгүй	2	2,049.0			2	2,049.0	-	-	-	-	-	-
Эд хөрөнгийн тооллогыг чанаргүй гүйцэтгэсэн	1	-					1	-				
Бодитоор оршин байхгүй үндсэн хөрөнгө бүртгэлтэй	1	1,865.6					1	1,865.6				
Дүн	5	7,002.6	-	-	3	5,137.0	2	1,865.6	-	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1				1		